



# ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Санхүүгийн зохицуулах хорооны  
Даатгалын газрын дарга С.Ганболд  
2014.11.20



## Товч агуулга

- Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд
- Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтын цаашдын чиг хандлага



# Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд

- ▶ Монгол Улсын даатгалын зах зээлийн зохицуулалтын өнөөгийн байдал:
  - *Даатгалын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан “Даатгалын зохицуулалтын эрх зүйн актын эмхтгэл” (2008 он, 2010 он, 2013 он)*
  - *Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо (IAIS)-ноос гаргасан Даатгалын олон улсын зарчмууд (ICPs)-д нийцүүлэх ажлын явц*
- ▶ Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратегийн баримт бичигт туссан даатгалын салбарын зорилтууд:
  - *Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт тавих зорилт (Risk Based Supervision)*
  - *Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх үүргийг боломжтой этгээдэд шилжүүлэх зорилт*
- ▶ Монгол Улсын Даатгалын салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх стратегийн баримт бичиг (2020 он хүртэл)
  - *Даатгалын салбарын эрх зүйн орчинг хөгжүүлэх*
  - *Даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх*



# Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд

- ▶ Даатгалын дэд бүтэц хөгжиж мэргэжлийн оролцогчдын тоо нэмэгдэж байна:
  - Даатгалын компани – 17, даатгалын салбар – 254, даатгалын төлөөлөгч – 3431
  - Даатгалын зуучлагч компани – 26, тэдгээрийн салбар – 78
  - Даатгалын хохирол үнэлэгч компани – 19, тэдгээрийн салбар – 22
- ▶ Даатгалын үйлчилгээ нэмэгдэж зах зээл хөгжиж байна:
  - Даатгалын салбарын нийт актив 1,1 дахин өссөн
    - 2013.III ул – 122,8 тэрбум төгрөг
    - 2014.III ул – 135,1 тэрбум төгрөг
  - Даатгалын нийт хураамж 1,2 дахин өссөн
    - 2013.III ул – 67,3 тэрбум төгрөг
    - 2014.III ул – 81,6 тэрбум төгрөг
  - Даатгалын нөхөн төлбөр олголт 1,33 дахин өссөн
    - 2013.III ул – 17,4 тэрбум төгрөг
    - 2014.III ул – 23,2 тэрбум төгрөг
  - Давхар даатгалын хураамж 1,26 дахин өссөн
    - 2013.III ул – 18,4 тэрбум төгрөг
    - 2014.III ул – 23,2 тэрбум төгрөг



# Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд

- ▶ Албан журмын жолоочийн даатгалын явцын байдал:
  - Жолоочийн даатгалын хураамж 1,32 дахин өссөн
    - 2013.Ш ул – 10,8 тэрбум төгрөг
    - 2014.Ш ул – 14,24 тэрбум төгрөг
  - Жолоочийн даатгалын нөхөн төлбөр 1,25 дахин өссөн
    - 2013.Ш ул – 6,3 тэрбум төгрөг
    - 2014.Ш ул – 7,8 тэрбум төгрөг
  - Даатгалын гэрээний тоо – 329331
  - Даатгалын тохиолдлын тоо – 16522
- ▶ Даатгалын зуучлалын байдал:
  - Зуучлалын орлого 3,4 дахин өсч 2,33 тэрбум төгрөг болсон
- ▶ Даатгалын хохирол үнэлгээний байдал:
  - Даатгалын хохирол үнэлгээний орлого 2,3 дахин өсч 454 сая төгрөг болсон



# Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд

- ▶ Даатгалын зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулах үйл явц:
  - Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалсан
  - Амьдралын даатгалыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалтай уялдуулах, тэтгэврийн даатгалыг хөгжүүлэх асуудлыг судалсан
  - Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хүрээнд давхар даатгалын үйл ажиллагааны зохицуулалт, хяналт шалгалтын эрх зүйн орчинг бүрдүүлж байна
  - Даатгалын компанийн өнөөгийн төлбөрийн чадварын орчинг Европын холбооны Төлбөрийн чадвар 1, 2-той харьцуулан судалсан
- ▶ Эрсдэлийн судалгаа хийх, журам зааврыг сайжруулах үйл явц:
  - Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, хүлээж болзошгүй эрсдэл (VaR)-ийн аргын талаар судалгаа хийсэн
  - Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналтын сэдвээр даатгалын компанийн ажилтнуудад зориулсан сургалтууд зохион байгуулсан
  - Даатгалын компанийн засаглалыг сайжруулахад чигэлсэн үе шатчилсан арга хэмжээ авсан





# Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд

Даатгалын салбарын зохицуулалтын орчинг сайжруулах ажил:

- ▶ Даатгалын компаниудад үнэт цаас, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, холбогдох журмуудад зохих нэмэлт өөрчлөлтийг оруулсан:
- ▶ Компанийн засаглалыг сайжруулахад чигэлсэн заалтыг журамд нэмж оруулсан
- ▶ Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн ажил
- ▶ Үндэсний давхар даатгалын компани байгуулах талаар судалгаа хийсэн
- ▶ ААНОАТ-ын хууль, ХХОАТ-ын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж Сангийн яам, Татварын ерөнхий газарт хүргүүлсэн
- ▶ Тусгай зөвшөөрлийн талаар судалгаа хийх ажлын хэсэгтэй хамтарч санал дүгнэлт боловсруулсан



# Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтын цаашдын чиг хандлага

Албан журмын даатгалын тулгамдсан асуудлууд:

- ▶ Мэргэшсэн жолоочийн даатгал янз бүр хийгдэж байна: Тухайлбал зарим компани мэргэшсэн жолоочийн хувьд тусдаа даатгалын гэрээ байгуулж байгаа бол зарим компани зөвхөн хураамж нэмж төлөх гэрээ байгуулж байна. Тусдаа гэрээ байгуулах нөхцөлд даатгалын үнэлгээг 10 сая төгрөгөөр тооцож байгаа тул 1 даатгалын тохиолдол үүсэхэд өмчлөгчийн даатгалын гэрээний үнэлгээ 10 сая төгрөг, мэргэшсэн жолоочийн даатгалын үнэлгээ 10 сая төгрөг нийт 20 сая төгрөгийн даатгалын үнэлгээтэй болж байгаа бол хураамж нэмж төлөх гэрээ байгуулснаар үнэлгээ зөвхөн 10 сая төгрөг байна. Иймд дээрх мэргэшсэн жолоочийн даатгалын заалтын хувьд өөр өөр практик хэрэглээ үүссэн байдалтай байна.
- ▶ Мэргэшсэн жолооч хэрэв даатгуулаагүй бол даатгалын нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн олгож байна.
- ▶ Даатгалын нөхөн төлбөрийн зардлыг Жолоочийн даатгалын тухай хууль болон Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний дагуу даатгалын компани төлөх үүрэгтэй хэдий ч энэ заалт төдийлөн хэрэгжихгүй байна.





# Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтын цаашдын чиг хандлага

Албан журмын даатгалын тулгамдсан асуудлууд:

- ▶ Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1.2 “даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын баталгааг шалгуулах”, 13.4 “даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол даатгагчид энэ тухайгаа мэдэгдэх бөгөөд даатгагчаас эргэн төлүүлэхээр даатгагчийн зааврын дагуу хохирлыг жолооч барагдуулж болно” гэсэн заалтууд хоорондоо зөрчилдөж байна.
- ▶ Даатгалын хохирол үнэлгээний компаниар үнэлүүлээд даатгалын компани дээр очихоор даатгагч тухайн хохирол үнэлгээний компанийг хүлээн зөвшөөрөхгүй, хохирол үнэлгээний мөнгийг болон үнэлсэн даатгалын нөхөн төлбөрийг олгохгүй тохиолдол олон гарч байна.
- ▶ Автомашины эзэмшигч өөрчлөгдөхөд хуучин гэрээг заавал цуцалж шинээр даатгалын гэрээ байгуулахыг шаарддаг, үүнтэй холбоотой үүсэх даатгалын хураамжийн буцаалтыг авах нь даатгуулагчид маш хүндрэлтэй байдаг. Даатгалын гэрээний үлдэх хугацааны төлбөрийг авахаар даатгалын компанид ханддаг хүний тоо маш цөөн байдаг, учир нь түгжирч явж компани дээрээ очоод 10 гаруй мянган төгрөг авна гэдэг нь даатгуулагчид бараг алдагдал хүлээхэд хүргэдэг.



# Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтын цаашдын чиг хандлага

Албан журмын даатгалын тулгамдсан асуудлууд:

- ▶ Санал: Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулж мэргэшсэн жолоочийн даатгалын заалтыг хүчингүй болгох, даатгалын хураамж болон үнэлгээний хэмжээг хуулиар бус журмаар зохицуулах, даатгалын гэрээний ард хавсралтын хэсэгтэй болгож эзэмшигч өөрчлөгдөхөд гэрээний хугацаанд зөвхөн нэр өөрчлөөд хураамж буцаахгүй, үргэлжлүүлэн гэрээг хэрэглэдэг байх, цагдаагийн акт заавал шаарддаг буруу тогтсон практикийг өөрчлөх, холбогдох хуулийн заалтыг өөрчлөх, даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын бий болгох.
- ▶ Мөн хуулийн 3.1.1 /жолоочийн тодорхойлолт/, 3.1.9 /даатгалын тохиолдлын тодорхойлолт, 19.9 /80 хувь ба 20 хувь/ дэх заалтуудыг өөрчлөх, АЖДХ ослыг бууруулах ажил хийх эрхтэй болох чиглэлээр хуульд нэмэлт оруулах.



# Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтын цаашдын чиг хандлага

## Даатгагчид болон даатгалын зуучлагч нарын хамтын ажиллагаа

Тээврийн хэрэгслийн оношлогооны төвийн ойролцоох түрээсийн газрууд түрээсийн төлбөрт сард 0,5-1,5 сая төгрөг авдаг байсныг бууруулах арга хэмжээ авч ажилласан ч давхар давхар түрээс төлж байна. Даатгалын төлөөлөгчдийн тоо нэмэгдэж, хоорондоо зүй бусаар харилцдаг, даатгалын компаниудын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх явдал гардаг. Мөн даатгалын төлөөлөгчдийн мэргэжлийн ур чадвар дутагдаж, даатгалын нөхцлийг буруу тайлбарлах, бүртгэлийг дутуу хийх, даатгалын хураамжийг зохих цаг хугацаанд нь тушаахгүй байх зэрэг нийтлэг дутагдал гарч байна.

Дээрх зөрчил дутагдлыг арилгах зорилгоор 2 арга хэмжээ авч ажилласан нь үр дүнд хүрсэн. Нэгдүгээрт 2013 оноос эхлэн мэдээллийн санг боловсронгуй болгож, даатгалын гэрээг программын тусламжтайгаар шууд хэвлэж, даатгалын бүртгэлийн системийг автотээврийн газар, албан журмын даатгагчдын холбоо, даатгалын байгууллагуудтай холбож ажиллуулж эхэлсэн нь даатгалын гэрээний бүртгэл хяналттай болсон. Хоёрдугаарт автотээврийн газрын бүртгэл болон оношлогооны төв дээр даатгалын зуучлалын компанийг ажиллуулснаар даатгуулагчдад зөв боловсон үйлчилгээ үзүүлж эхэлж, даатгагч, зуучлагчдын хамтын ажиллагаанд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн.

Санал: Даатгалын зуучлагч банкуудад бүх даатгагчидтай хамтарч ажиллах шаардлагыг тавьж, банкуудыг жолоочийн албан журмын даатгалын борлуулалт хийхдээ орон нутгийн салбартай бүх даатгалын компаниудад даатгуулах боломжийг хангуулах.

Автотээврийн газрын бүртгэл, оношлогооны төвд Даатгагчдын холбоо, АЖДХ-ны сонгон шалгаруулсан зуучлагч компаниудыг ажиллуулах журам боловсруулж хэрэгжүүлэх.



# Даатгалын салбарт тулгамдаж байгаа асуудлууд, шийдвэрлэх арга зам

## Даатгагчид болон даатгалын хохирол үнэлэгч нарын хамтын ажиллагаа

Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтаар “даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, даатгуулагч өргөдөл гаргаснаас хойш 3 хоногийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж, даатгалын хохирол үнэлэгчийг томилох үүрэгтэй” гэж даатгалын хохирол тогтоох үйл ажиллагааны эрхийг даатгагчид олгосон. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлж хохирлыг үнэн бодитой тогтоох зорилготойгоор даатгалын компаниуд хохирол үнэлгээний эрх авсан компаниудтай хамтран ажиллаж байгаа боловч даатгалын тохиолдол бүр дээр үнэлгээчийг томилж хохирлыг тодорхойлуулж чадахгүй байна. Хуулийн энэ заалтыг даатгуулагч, хохирогч мэдэхгүй байгаагаас даатгагчийг хий хардаж байна. Даатгагч эрхээ хэрэгжүүлж хэд хэдэн хохирол үнэлэгчийг томилоход хохирогч эсвэл даатгуулагч алийг нь ч зөвшөөрөхгүй хэл ам гаргаж өөрийн хүссэн газраараа хохирлоо тодорхойлуулах гэж явахдаа даатгалын компанийн буруугаас болсон гэж ташаа ойлгон бухимдах тохиолдол гарч байна.

Санал: Даатгагч хохирол үнэлэгчийг томилох эрхээ хэрэгжүүлэхэд төрийн зохицуулалт, хяналтыг сайжруулах. Даатгалын хохирол үнэлэгчид өндөр шаардлага тавьж, хяналтыг сайжруулах. Даатгалын нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх асуудлыг даатгалын зуучлагч, хохирол үнэлгээчдэд хариуцуулж, тэдний хамтын ажиллагааг сайжруулахад анхаарч, хохирол үнэлгээ, нөхөн төлбөрийн шинэ тогтолцоог бий болгох.



# Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналт шалгалтын тулгамдсан асуудлууд

- ▶ Жолоочийн даатгалын хураамжийн орлого даатгалын нийт хураамжийн 18 хувийг, жолоочийн даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 34 хувийг эзэлж байгаа нь хохирлын харьцааг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Даатгагчийн хохирлын харьцаа 42 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2,4 пунктээр нэмэгдсэнийг судалж, дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ▶ Даатгалын компаниудын төлбөрийн чадварын үзүүлэлтийг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай болсон байна.
- ▶ Даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг сайжруулж, найрийвчлан боловсруулж мөрдүүлэх шаардлагатай байна.
  - Даатгалын зуучлагч компани
  - Даатгалын зуучлагч арилжааны банк
  - Даатгалын хохирол үнэлэгч компани



# Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтын цаашдын чиг хандлага

- ▶ Даатгалын андерратинг хийх нөхцөл шаардлагыг боловсруулж мөрдүүлэх анхаарах асуудал:
  - Даатгалын андеррайтингийн сургалтууд зохион байгуулах
  - Даатгалын андеррайтингийн гарын авлага гаргах
  
- ▶ Даатгалын мэргэжлийн актуарч бэлдэхэд онцгойлон анхаарах:
  - Даатгалын актуарчийн сургалтууд хамтарч зохион байгуулах
  - Даатгалын компаниудаас актуарын тайланг хүлээн авч хянах
  
- ▶ Эсдэлийн үнэлгээнд суурилсан даатгалын хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхэд анхаарах:
  - Даатгалын байгууллагуудын эрсдэлийг таньж мэдэх
  - Даатгалын байгууллагуудын эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийн түвшингээр нь ангилах
  - Эсдэлийг бууруулах талаар хамтарч ажиллах





Даатгалын салбарын 80 жилийн  
ойн баярын мэнд дэвшүүлье!



**Анхаарал тавьсанд баярлалаа!**